



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

「Жуулчдад зориулсан бэсрэг Даншиг наадам
зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, “Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн
ТУШААХ нь:

1.Монголын соёл, шашны зан үйлийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор жуулчдад зориулсан бэсрэг даншиг наадмыг 2025 оны 08 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд Монгол номадик жуулчны баазад зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

